# МОНГОЛ УЛСЫН ГАДААД СЕКТОРЫН ТОЙМ

**2017 НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН ГҮЙЦЭТГЭЛ**

## I. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

Урсгал ба хөрөнгийн данс 2017 оны 1 дүгээр улиралд 157 сая ам.долларын алдагдалтай, санхүүгийн данс 106 сая ам.долларын ашигтай, нийт төлбөрийн тэнцэл 164 сая ам.долларын алдагдалтай буюу гадаад валютын улсын нөөц уг дүнгээр буурсан. Статистикийн алдаа ба орхигдуулгын дүн -113 сая ам.доллар байна.

2016 оны 1 дүгээр улирлын гүйцэтгэлтэй харьцуулахад урсгал ба хөрөнгийн дансны алдагдал 6 сая ам.доллараар өсч, санхүүгийн дансны ашиг 178 сая ам.доллараар буурсан үзүүлэлттэй байна.

Гадаад валютын улсын нөөц тайлант улирлын эцсийн байдлаар 1,109 сая ам.доллар буюу сүүлийн 3 сарын дунджаар тооцсон импортын 3.3 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

**Дүрсэл 1. Төлбөрийн тэнцэл**




## Барааны худалдаа

Төлбөрийн тэнцлийн аргачлалаар тооцсон барааны худалдааны эргэлт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 24% -иар өсч 2,001 сая ам.долларт хүрсэн бөгөөд барааны худалдааны тэнцэл 418 сая ам.долларт хүрч, сүүлийн 11 улирал дараалан ашигтай гарч байна.
Үүнд, нефтийн импорт 2017 оны 1 дүгээр улиралд өмнөх оны мөн үеэс 71 сая ам.доллараар (12%), хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмж, бүх төрлийн автомашины импорт 78 сая ам.доллларaaр (13%), нүүрсний экспорт 440 сая ам.доллараар (46%) тус тус нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

**Дүрсэл 2. Барааны худалдаа**




## Үйлчилгээний худалдаа

2017 оны 1 дүгээр улиралд үйлчилгээний худалдааны алдагдал өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 13%-иар буюу 44 сая ам.доллараар өсч 372 сая ам.долларт хүрсэн байна.

Энэ алдагдалын өсөлтөнд тээврийн үйлчилгээний зардал өмнөх оноос 49 сая ам.доллараар, үүнд ачаа тээврийн зардал өссөн нь голлон нөлөөлжээ.

**Дүрсэл 3. Үйлчилгээний худалдаа**




## Анхдагч орлого

Анхдагч орлогын данс 256 сая ам.долларын алдагдалтай гарч өнгөрсөн оны мөн үеэс 0.6%-иар буюу 1 сая ам.доллараар өссөн.

Тайлант улиралд, гадаад бонд үнэт цаасны хүүгийн төлбөрт 57 сая ам.доллар, ногдол ашигт 44 сая ам.доллар, хөрөнгө оруулагчдийн зээлийн хүүгийн төлбөрт 36 сая ам.доллар, бусад зээлийн хүүгийн төлбөрт 43 сая ам.доллар, банкууд гадаад зээл болон харилцах, хадгаламжийн дансны хүүгийн төлбөрт нийт 28 сая ам.доллар тус тус төлсөн байна.

## Хоёрдогч орлого

Хувийн гуйвуулга болон хандив тусламжийн орлогын хувьд 2017 оны 1 дүгээр улиралд манай улс нийт 52 сая ам.доллар буюу өнгөрсөн оноос 4 сая ам.доллараар их орлогыг хүлээн авсан байна. Үүнд:

- Гадаадад ажиллаж, амьдарч буй Монгол иргэдээс хүлээн авсан гуйвуулга өмнөх оны мөн үеэс 9.1%-иар, гадаад руу шилжүүлсэн иргэдийн гуйвуулга 45.8%-иар тус тус өссөн,
- Хандив, тусламжийн орлого өмнөх оны мөн үеэс 6%-иар өссөн үзүүлэлттэй байна.

**Хүснэгт 1. Хувийн гуйвуулга 2017, I улирал (улсаар, мян ам.доллар)**

| | Хүлээн авсан | | | Шилжүүлсэн | | |
|---|---|---|---|---|---|---|
| | Мөнгөн дүн | Хувийн жин | Өсөлт | Мөнгөн дүн | Хувийн жин | Өсөлт |
| Солонгос | 25,461 | 49% ▲ | 41% | 2,440 | 10% ▲ | 21% |
| Америк | 6,499 | 12% ▲ | 14% | 10,045 | 40% ▲ | 164% |
| Хятад | 3,557 | 7% ▼ | -1% | 3,840 | 15% ▼ | -21% |
| Гонг Конг | 1,248 | 2% ▼ | -31% | 424 | 2% ▼ | -56% |
| Англи | 3,725 | 7% ▲ | 104% | 793 | 3% ▼ | -9% |
| ОХУ | 1,042 | 2% ▲ | 2% | 1,520 | 6% ▼ | -22% |
| Сингапур | 913 | 2% ▲ | 56% | 894 | 4% ▼ | -51% |
| Швейцарь | - | 0% ▼ | -100% | - | 0% ▼ | -100% |
| Герман | 1,247 | 2% ▲ | 4% | 1,112 | 4% ▲ | 165% |
| Япон | 1,563 | 3% ▲ | 3% | 514 | 2% ▼ | -17% |
| Бусад | 7,172 | 14% ▼ | -52% | 3,462 | 14% ▼ | -39% |
| **НИЙТ** | **52,426** | **100%** | | **25,045** | **100%** | |

## Гадаадын шууд хөрөнгө оруулалт

2017 оны 1 дүгээр улиралд Монгол улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалт цэвэр дүнгээр 140 сая ам.долларын орох урсгалтай байна. Үүнд хөрөнгө оруулалтын орох урсгалын дүн 246 сая ам.доллараар өсч, хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлттэй холбоотой гарах урсгал 106 сая ам.доллараар буурсан байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлтэй харьцуулбал 141 сая ам.доллараар буурсан байна. Энэ нь хөрөнгө оруулагчын зээл олголт буурсантай холбоотой байна.

Шууд хөрөнгө оруулалтын орох урсгалыг улсаар нь авч үзвэл,

- Люксенбург улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт өмнөх оны мөн үеэс 31 сая ам.доллараар өсч 42 сая ам.доллар,
- Хонг Конг улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 16 сая ам.доллараар нэмэгдэж 32 сая ам.доллар,
- Канад улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 98 сая ам.доллараар буурч 36 сая ам.доллар,
- Англи улсаас орж ирсэн хөрөнгө оруулалт 77 сая ам.доллараар буурч 2 сая ам.долларын урсгалтай гарсан байна.

Харин эдийн засгийн үйл ажиллагааны салбараар авч үзвэл 2017 оны 1 дүгээр улиралд уул уурхайн болон зочид буудал, байр, сууц, нийтийн хоолны үйлчилгээний салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээ өнгөрсөн оны гүйцэтгэлээс буурсан байна.

Салбаруудын хөрөнгө оруулалтын хэмжээг харьцуулбал,

- Барилгын салбарын компаниудынх 9 сая ам.доллараар,
- Үл хөдлөх хөрөнгийн салбарынх 6 сая ам.доллараар тус тус өссөн.
- Харин зочид буудал, байр, орон сууцны салбарт орсон хөрөнгө оруулалт 65 сая ам.доллар,
- Уул уурхайн салбарт орсон хөрөнгө оруулалт 75 сая ам.доллараар,
- Үйлчилгээний бусад үйл ажиллагаа 9 сая ам.доллараар,
- Бөөний болон жижиглэнгийн худалдааны салбарынх 6 сая ам.доллараар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

## Багцын хөрөнгө оруулалт

Багцын хөрөнгө оруулалтын данс 2017 оны 1 дүгээр улиралд 43 сая ам.долларын алдагдалтай гарч, өнгөрсөн оны мөн үеэс 48 сая ам.доллараар өссөн байна.
Голлох ажил гүйлгээг дурдвал:

- Засгийн газрын гаргасан Хуралдай бондод 126 сая ам.доллар орж ирсэн (600 сая ам.долларын Хуралдай бондын 474 сая ам.доллар нь ХБ-ны бондоор солигдсон),
- Хөгжлийн банкны 580 саяын бондын эргэн төлөлтөд 104 сая ам.долларыг төлсөн,
- ХХБ-ны 7000 сая юаны бондын эргэн төлөлтөд 102 сая ам.долларыг төлсөнтэй холбоотой байна.

## Бусад хөрөнгө оруулалт

Энэ дансанд санхүүгийн дээрх дансуудад үл хамаарах бусад хөрөнгө оруулалтууд буюу бусад бүх төрлийн зээл (арилжааны, хөнгөлөлттэй, худалдааны г.м), бэлэн мөнгө ба харилцах хадгаламжийн дансны эх үүсвэрийг бүртгэдэг.

Тайлант улиралд бусад хөрөнгө оруулалтын данс 27 сая ам.долларын ашигтай гарсан бөгөөд үүнийг өнгөрсөн оны үзүүлэлттэй харьцуулбал тэнцэл 38 сая ам.доллараар буурсан дүнтэй байна.

**Хүснэгт 2. ГШХО, орох урсгал, улсаар (сая ам.доллар)**

| № | Үзүүлэлт | I улирал | | 2017.I/16.I | |
|---|---|---|---|---|---|
| | | Дүн | Хувийн жин | Өөрчлөлт | |
| 1 | Австрали | 3.3 | 1% | -8.7 | ▼ |
| 2 | Америк | 24.9 | 10% | 7.0 | ▲ |
| 3 | Англи | 2.3 | 1% | -77.4 | ▼ |
| 4 | БНХАУ | 31.9 | 13% | -16.1 | ▼ |
| 5 | Герман | 0.9 | 0% | 0.4 | ▲ |
| 6 | Голланд | 0.2 | 0% | -0.9 | ▼ |
| 7 | Гонг-Конг | 35.4 | 14% | 16.3 | ▲ |
| 8 | Канад | 36.0 | 15% | -98.2 | ▼ |
| 9 | Люксенбург | 42.0 | 17% | 31.3 | ▲ |
| 10 | ОХУ | 2.0 | 1% | 1.2 | ▲ |
| 11 | Сингапур | 36.6 | 15% | 11.4 | ▲ |
| 12 | Солонгос (өмнөд) | 3.3 | 1% | 0.8 | ▲ |
| 13 | Турк | 0.6 | 0% | 0.4 | ▲ |
| 14 | Франц | 2.2 | 1% | 1.0 | ▲ |
| 15 | Япон | 13.7 | 6% | 4.0 | ▲ |
| 16 | Бусад | 11.1 | 5% | -12.7 | ▼ |
| | **Нийт** | **245.7** | **100%** | **-140.6** | ▼ |

**Хүснэгт 3. ГШХО, орох урсгал, салбараар (сая ам.доллар)**

| № | Эдийн засгийн салбар | I улирал | | 2017.I/16.I | |
|---|---|---|---|---|---|
| | | 2016 | 2017 | Өөрчлөлт | |
| 1 | Барилга | 11.9 | 21.2 | 9.2 | ▲ |
| 2 | Боловсрол | 2.2 | 0.8 | -1.4 | ▼ |
| 3 | Боловсруулах үйлдвэрлэл | 3.7 | 6.0 | 2.3 | ▲ |
| 4 | Бөөний болон жижиглэн худалдаа; машин, мотоциклийн засвар үйлчилгээ | 22.4 | 16.3 | -6.1 | ▼ |
| 5 | Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ | 71.4 | 6.2 | -65.2 | ▼ |
| 6 | Мэдээлэл, холбоо | 6.3 | 3.5 | -2.8 | ▼ |
| 7 | Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа | 6.7 | 4.1 | -2.6 | ▼ |
| 8 | Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа | 15.4 | 21.8 | 6.4 | ▲ |
| 9 | Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа | 3.8 | 1.7 | -2.0 | ▼ |
| 10 | Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа | 6.1 | 7.3 | 1.2 | ▲ |
| 11 | Уул уурхай, олборлолт | 185.2 | 110.6 | -74.6 | ▼ |
| 12 | Үйлчилгээний бусад үйл ажиллагаа | 21.3 | 12.3 | -9.0 | ▼ |
| 13 | Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа | 7.8 | 14.1 | 6.3 | ▲ |
| 14 | Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур | 2.0 | 4.6 | 2.6 | ▲ |
| 15 | Цахилгаан, хий, уур, агааржуулалт | 6.9 | 9.4 | 2.6 | ▲ |
| 16 | Бусад | 13.0 | 5.7 | -7.4 | ▼ |
| | **Нийт** | **386.3** | **245.7** | **-140.6** | ▲ |

**Дүрслэл 4. Багцын хөрөнгө оруулалт (сая ам.доллар)**




**Дүрслэл 5. Бусад хөрөнгө оруулалт**



# II. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦ

Монгол Улсын гадаад хөрөнгө оруулалтын позиц 2017 оны 1 дүгээр улирлын эцэст цэвэр дүнгээр 30,178 сая ам.долларын өр төлбөртэй байна.

Монгол Улсын эдийн засгийн харьяатаас гадагш хийсэн хөрөнгө оруулалтын дүн (актив) 3,913 сая ам.доллар байна. Үүний 52%-ийг бусад хөрөнгө оруулалтын актив, 28%-ийг гадаад валютын улсын нөөц, 12%-ийг шууд хөрөнгө оруулалт, 6%-ийг багцын хөрөнгө оруулалт, 1%-ийг санхүүгийн үүсмэл хэрэгслүүд тус тус эзэлж байна.

Харин гадаадаас Монгол Улсын эдийн засгийн харьяатад гадаадаас оруулсан хөрөнгө оруулалтын дүн (пассив) 34,091 сая ам.долларт хүрчээ. Үүний 48%-ийг гадаадын шууд хөрөнгө оруулалт, 40%-ийг бусад хөрөнгө оруулалт, үлдсэн 11%-ийг багцын хөрөнгө оруулалт тус тус бүрдүүлж байна.

Гадаад хөрөнгө оруулалтын позиц цэвэр дүнгээр өмнөх оны мөн үеэс 4%-иар буюу 1,106 сая ам.доллараар буурч -30,178 сая ам.долларт хүрсэн. Энэ нь:

- Ерөнхий бүтцээр авч үзвэл, гадаад актив 7%-иар буюу 287 сая ам.доллараар буурч, гадаад пассив 2%-иар буюу 820 сая ам.доллараар өссөнөөр,
- Данс тус бүрээр авч үзвэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтын позиц 4,448 сая ам.доллараар, санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн позиц 51 сая ам.доллараар тус тус өссөнөөр, харин багцын хөрөнгө оруулалтын позиц 775 сая ам.доллараар, бусад хөрөнгө оруулалтын позиц 4,675 сая ам.доллараар, гадаад валютын нөөц 156 сая ам.доллалаар тус тус буурснаар тайлбарлагдаж байна.
- Позицийн өөрчлөлтийг бүтцээр авч үзвэл, төлбөрийн тэнцлийн урсгалаар –270 сая ам, үнийн өөрчлөлтөөр –306 сая, бусад өөрчлөлтөөр –167 сая, ханшийн зөрүүгээр –83 сая ам.доллараар тус тус өөрчлөгджээ.

**Хүснэгт 4. Позиц (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | 3/31/2016 | 3/31/2017 | Өөрчлөлт дүн | Өөрчлөлт хувь |
|---|---|---|---|---|
| **Гадаад хөрөнгө оруулалтын позиц** | **-29,072** | **-30,178** | **1,106** | **4%** |
| **I. Гадаад актив** | **4,200** | **3,913** | **-287** | -7% |
| 1. Шууд хөрөнгө оруулалт | 441 | 458 | 17 | 4% |
| 2. Багцын хөрөнгө оруулалт | 196 | 251 | 55 | 28% |
| 3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл | 120 | 55 | -64 | -54% |
| 4. Бусад хөрөнгө оруулалт | 2,178 | 2,040 | -138 | -6% |
| 5. Нөөц актив | 1,265 | 1,109 | -156 | -12% |
| **II. Гадаад пассив** | **33,272** | **34,091** | **820** | **2%** |
| 1. Шууд хөрөнгө оруулалт | 20,903 | 16,472 | -4,431 | -21% |
| 2. Багцын хөрөнгө оруулалт | 3,048 | 3,877 | 830 | 27% |
| 3. Санхүүгийн үүсмэл хэрэгсэл | 170 | 54 | -116 | -68% |
| 4. Бусад хөрөнгө оруулалт | 9,151 | 13,688 | 4,537 | 50% |

**Дүрслэл 6. Гадаад актив, пассив**




## Шууд хөрөнгө оруулалт

Монгол Улсад орсон гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 54%-ийг буюу 8,947 сая ам.долларыг хувь нийлүүлэгчийн дүрмийн сан дахь хөрөнгө оруулалт, үлдсэн 46% буюу 7,525 сая ам.долларыг толгой компаниасаа авсан зээл (компани хоорондын өглөг, санхүүжилт) эзэлж байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын үлдэгдлийг хөрөнгө оруулагч улсаар нь харуулбал:

- БНХАУ-аас 4,726 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын 29%,
- Канад улсаас 4,396 сая ам.доллар буюу 27%,
- Хонг Конг улсаас 1,450 сая ам.доллар буюу 9%,
- Сингапур улсаас 1,338 сая ам.доллар буюу нийт хөрөнгө оруулалтын үлдэгдлийн 8%-тай тэнцэх хэмжээний хөрөнгө оруулалтуудыг тус тус оруулсан байна.

**Дүрслэл 7. Шууд ХО-ын үлдэгдэл, 2017 оны 1 дүгээр улирал**




## Багцын хөрөнгө оруулалт

Монгол Улсын багцын хөрөнгө оруулалтын гадаад активын үлдэгдэл 2017 оны 1 дүгээр улирлын эцэст 251 сая ам.долларт хүрч өнгөрсөн оны мөн үеэс 28%-иар, харин гадаад пассивын үлдэгдэл 3,877 сая ам.долларт хүрч 27%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

**Актив:** эдийн засгийн харьяатуудын эзэмшиж буй үнэт цаасыг гаргасан улсаар нь авч үзвэл Гонг конг 62%, Австрали 12%, АНУ 8%, Сингапур 6%, Канад улс 4%-ийг тус тус эзэлж байна.

**Пассив:** эдийн засгийн харьяатуудын гаргасан үнэт цаасыг эзэмшигч улсаар нь ангилбал Сингапур 21%, Гонг конг 14%, бусад улс 19%, харин 42% нь эзэмшигч тодорхойгүй буюу хоёрдогч зах зээл дээр арилжаалагдаж байгаа үнэт цаас эзэлж байна.

**Дүрслэл 8. Багцын ХО-ын үлдэгдэл, 2017 оны 1 дүгээр улирал**



# III. ГАДААД ӨРИЙН СТАТИСТИК

Монгол Улсын нийт гадаад өр (хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хөрөнгө оруулалтаас бусад гадаад өр төлбөр)-ийн үлдэгдэл 2017 оны 1 дүгээр улирлын эцсийн байдлаар 24,957 сая ам.долларт хүрч өмнөх оны мөн үеийн гүйцэтгэлээс 1,498 сая ам.доллараар нэмэгдсэн байна.

**Улсын салбар:** Засгийн газрын гадаад өр 1,772 сая ам.доллараар нэмэгдэж 5,845 сая ам.долларт, харин Монголбанкны гадаад өр 344 сая ам.доллараар буурч 1,741 сая ам.долларт хүрчээ.

**Бусад салбар:** Банк, бусад секторын болон хөрөнгө оруулагчийн зээлийг бүхэлд нь хувийн хэвшлийн салбарын гадаад өр гэж ойлгох бөгөөд өнгөрсөн оны мөн үеэс 70 сая

**Хүснэгт 5. Нийт гадаад өрийн үлдэгдэл (сая ам.доллар)**

| Үзүүлэлт | 3/31/2016 | 3/31/2017 | Өөрчлөлт дүн | Өөрчлөлт хувь | * % |
|---|---|---|---|---|---|
| **Нийт гадаад өр** | **23,459** | **24,957** | **1,498** | **6%** | **100%** |
| **I. Засгийн газар** | **4,073** | **5,845** | **1,772** | **44%** | **23%** |
| **II. Төв банк** | **2,084** | **1,741** | **-344** | **-16%** | **7%** |
| **III. Банк** | **2,182** | **2,382** | **201** | **9%** | **10%** |
| Богино хугацаат | 444 | 501 | 57 | 13% | 2% |
| Урт хугацаат | 1,738 | 1,882 | 144 | 8% | 8% |
| **IV. Бусад сектор** | **3,787** | **7,464** | **3,678** | **97%** | **30%** |
| Богино хугацаат | 343 | 435 | 91 | 27% | 2% |
| Урт хугацаат | 3,444 | 7,030 | 3,586 | 104% | 28% |
| **V. Хөрөнгө оруулагчаас авсан зээл** | **11,333** | **7,525** | **-3,808** | **-34%** | **30%** |

**: Нийт өсөлтөд оруулсан хувь*

## Банкны салбар

**Дүрслэл 9. Банкны салбарын гадаад зээл**




Банкны салбарын гадаад пассивын үлдэгдэл 2017 оны 1 дүгээр улиралд 2,382 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9%-иар буюу 201 сая ам.доллараар нэмэгджээ.

Гадаад пассивын 44%-ийг урт хугацаат зээл, 25%-ийг бонд өрийн бичиг, 21%-ийг богино хугацаат зээл, үлдсэн 11%-ийг эдийн засгийн харьяат бусын эзэмшиж буй харилцах, хадгаламжийн дансны өглөг тус тус бүрдүүлж байна.

Банкуудын урт болон богино хугацаат арилжааны зээлийн үлдэгдэл харгалзан 1,038 сая ам.доллар, 501 сая ам.долларт хүрээд байна.

## Банкнаас бусад салбар

**Дүрслэл 10. Банк бус хувийн хэвшлийн гадаад зээл**




Банкнаас бусад салбарын буюу аж ахуйн нэгж, иргэдийн гадаад пассив 2017 оны 1 дүгээр улирлын эцэст 14,989 сая ам.долларт хүрч, өнгөрсөн оны мөн үеийн гүйцэтгэлээс 130 сая ам.доллараар буурсан дүнтэй байна.

Салбарын нийт зээлийн 48% буюу 7,525 сая ам.долларын эх үүсвэр нь аж ахуйн нэгж, байгууллагуудын гадаадын хөрөнгө оруулагчдаасаа авсан зээл буюу компани хоорондын өглөг бөгөөд үүний дийлэнх нь уул уурхайн салбарт ашиглагдсан байна.

Хөрөнгө оруулагчдаас авсан зээлийн эх үүсвэр нь компанийн эргэлтийн хөрөнгө, мөнгөн урсгалыг дэмжих зорилгоор олгогддог урт хугацаат санхүүжилт бөгөөд ихэнх тохиолдолд хүүгүй, хатуу мөрдөх эргэн төлөлтийн хуваарь байхгүй, харилцан тохиролцсоны үндсэн дээр цаашид дүрмийн санд нэмж тооцогдох боломжтой байдгаараа бусад төрлийн зээлийн санхүүжилтээс ялгаатай байдаг.

Эдийн засгийн харьяат аж ахуйн нэгжүүдийн гадаадаас хүлээн авсан экспортын барааны урьдчилгаа болон төлбөрийг хийгээгүй боловч хүлээн авсан импортын барааны төлбөрийн үлдэгдэл тайлант улирлын эцсийн байдлаар 219 сая ам.доллар болсон байна.

**Мэдээллийн эх сурвалж:**

1. Засгийн газар: Сангийн яам, Өрийн удирдлагын хэлтэс
2. Монголбанк: ТТБГазар, ССГазар
3. Банк: Банкуудын тайлан тэнцэл, төлбөрийн тэнцлийн сарын мэдээ, гадаад зээлийн бүртгэл
4. Бусад салбар: ААН-ийн Төлбөрийн тэнцлийн улирлын мэдээ, банкуудын гадаад гүйлгээний тайлан, гадаад зээлийн бүртгэлийн мэдээллийг тус тус ашиглав.

# ХАВСРАЛТ 1. МОНГОЛ УЛСЫН ТӨЛБӨРИЙН ТЭНЦЛИЙН ХУРААНГУЙ ХҮСНЭГТ (сая ам.доллар)

| Үзүүлэлт | I улирал | | | Өөрчлөлт | | Өөрчлөлт | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 2015 | 2016 | 2017 | Дүн | 2016/15 | Дүн | 2017/16 |
| **I. УРСГАЛ ДАНС** | **-60** | **-165** | **-171** | **-105** | **-175%** | **-6** | **-4%** |
| **Бараа ба үйлчилгээний худалдаа** | **147** | **45** | **46** | **-102** | **-69%** | **1** | **2%** |
| **Кредит** | **1,217** | **1,102** | **1,381** | **-115** | **-9%** | **278** | **25%** |
| **Дебет** | **1,070** | **1,057** | **1,334** | **-13** | **-1%** | **277** | **26%** |
| **1. Бараа** | **384** | **373** | **418** | **-11** | **-3%** | **45** | **12%** |
| 1.1 Экспорт Ф.О.Б (кредит) | 1,104 | 992 | 1,210 | -112 | -10% | 217 | 22% |
| 1.2 Импорт Ф.О.Б (дебит) | 720 | 619 | 791 | -101 | -14% | 172 | 28% |
| **2. Үйлчилгээ** | **-237** | **-328** | **-372** | **-91** | **-39%** | **-44** | **-13%** |
| Кредит | 113 | 110 | 171 | -3 | -2% | 61 | 55% |
| Дебет | 350 | 438 | 543 | 88 | 25% | 105 | 24% |
| 2.1 Тээвэр | -36 | -48 | -97 | -12 | -35% | -49 | -102% |
| Кредит | 45 | 40 | 63 | -5 | -12% | 24 | 59% |
| Дебит | 81 | 88 | 161 | 7 | 9% | 73 | 83% |
| 2.2 Аялал | -87 | -90 | -101 | -3 | -3% | -11 | -13% |
| Кредит | 21 | 24 | 36 | 3 | 12% | 12 | 51% |
| Дебит | 108 | 114 | 137 | 6 | 5% | 24 | 21% |
| 2.3 Бусад үйлчилгээ | -114 | -190 | -174 | -76 | -66% | 17 | 9% |
| Кредит | 46 | 46 | 71 | 0 | 0% | 25 | 54% |
| Дебит | 160 | 236 | 245 | 76 | 47% | 9 | 4% |
| **3 Анхдагч орлого** | **-222** | **-255** | **-256** | **-33** | **-15%** | **-1** | **-1%** |
| Кредит | 13 | 13 | 18 | 0 | -2% | 6 | 44% |
| Дебет | 235 | 268 | 275 | 32 | 14% | 7 | 3% |
| 3.1 Ажилчдын цалин | -10 | -16 | -10 | -6 | -61% | 6 | 36% |
| 3.2 Хөрөнгө оруулалтын орлого | -212 | -239 | -246 | -27 | -13% | -7 | -3% |
| 3.3 Бусад | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| **4 Хоёрдогч орлого** | **15** | **44** | **39** | **30** | **201%** | **-6** | **-13%** |
| Кредит | 53 | 64 | 65 | 11 | 22% | 1 | 2% |
| Дебит | 38 | 20 | 26 | -18 | -48% | 7 | 34% |
| Үүнээс: Хувийн гуйвуулга | 4 | 5 | 7 | 2 | 39% | 1 | 22% |
| **II. ХӨРӨНГИЙН ДАНС** | **11** | **39** | **32** | **28** | **259%** | **-7** | **-18%** |
| **1. Үйлдвэрлэхгүй санхүүгийн бус хөрөнгийн өсөлт/ бууралт** | **22** | **14** | **14** | **-7** | **0%** | **0** | **0%** |
| Кредит | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| Дебет | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| **2. Хөрөнгийн шилжүүлэг** | **0** | **0** | **0** | **0** | **0%** | **0** | **0%** |
| Кредит | 22 | 14 | 14 | -7 | -33% | 0 | -1% |
| Дебет | 22 | 15 | 19 | -7 | -32% | 5 | 31% |
| | 0 | 1 | 5 | 0 | 0% | 5 | 0% |
| **Урсгал болон Хөрөнгийн дансны тэнцэл (ээлдүүлэг + / ээллэг -)** | **-39** | **-151** | **-157** | **-112** | **-292%** | **-6** | **-4%** |
| **III. САНХҮҮГИЙН ДАНС** | | | | | | | |
| **Санхүүгийн дансны тэнцэл (ээлдүүлэг + / ээллэг -)** | **-284** | **-284** | **-106** | **0** | **0%** | **178** | **63%** |
| **1. Шууд хөрөнгө оруулалт** | **113** | **-214** | **-137** | **-327** | **-288%** | **77** | **36%** |
| 1.1 Актив | 2 | 3 | 3 | 1 | 44% | 0 | -12% |
| 1.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 2 | 3 | 3 | 1 | 44% | 0 | -12% |
| 1.1.2 Өрийн хэрэгсэл | 0 | 0 | 0 | 0 | - | 0 | 0% |
| 1.2 Пассив | -111 | 216 | 140 | 328 | 294% | -77 | -36% |
| 1.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 24 | 26 | 77 | 2 | 10% | 50 | 192% |
| 1.2.2 Өрийн хэрэгсэл | -135 | 190 | 63 | 326 | 240% | -127 | -67% |
| **2. Багцын хөрөнгө оруулалт** | **15** | **-5** | **43** | **-20** | **-137%** | **48** | **887%** |
| 2.1 Актив | 8 | 3 | 0 | -5 | -67% | -3 | -117% |
| 2.1.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 8 | 3 | 0 | -5 | -67% | -2 | -98% |
| 2.1.2 Өрийн бичиг | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 2.2 Пассив | -7 | 8 | -43 | 15 | 213% | -51 | -643% |
| 2.2.1 Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх | 2 | 0 | 0 | -2 | -85% | 0 | 43% |
| 2.2.2 Өрийн бичиг | -9 | 8 | -44 | 17 | 186% | -51 | -669% |
| 2.2.2.1 Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 2.2.2.2 Урт хугацаат | -9 | 8 | -44 | 17 | 186% | -51 | -669% |
| **3. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд** | **0** | **0** | **15** | **0** | **-24%** | **15** | **11058%** |
| 3.1 Актив | -7 | 5 | -46 | 13 | 171% | -51 | -989% |
| 3.2 Пассив | -8 | 5 | -61 | 13 | 167% | -66 | -1318% |
| **4. Бусад хөрөнгө оруулалт** | **-99** | **-65** | **-27** | **35** | **35%** | **38** | **58%** |
| 4.1 Актив | 2 | 394 | -155 | 392 | 21796% | -549 | -139% |
| 4.1.1 Бусад хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 4.1.2 Бэлэн мөнгө ба харилцах | -5 | 323 | -155 | 328 | 6183% | -478 | -148% |
| 4.1.3 Зээл | 0 | 12 | 0 | 11 | 2578% | -11 | -96% |
| 4.1.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 4.1.5 Худалдааны зээл ба урьдчилгаа | 7 | 59 | -1 | 53 | 791% | -60 | -101% |
| 4.1.5.1 Богино хугацаат | 7 | 59 | -1 | 53 | 791% | -60 | -101% |
| 4.1.5.2 Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 4.1.5 Бусад авлага | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 4.2 Пассив | 101 | 459 | -128 | 358 | 353% | -587 | -128% |
| 4.2.1 Бусад хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 4.2.2 Бэлэн мөнгө ба харилцах | 273 | 201 | 17 | -73 | -27% | -184 | -92% |
| 4.2.3 Зээл | -7 | 280 | -132 | 286 | 4148% | -412 | -147% |
| 4.2.3.1 Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 4.2.3.3 Хадгаламжийн байгууллагууд | -2 | -17 | -44 | -15 | -732% | -28 | -168% |
| 4.2.3.3.1 Богино хугацаат | -19 | 26 | 19 | 45 | 232% | -7 | -26% |
| 4.2.3.3.2 Урт хугацаат | 17 | -42 | -63 | -60 | -342% | -21 | -50% |
| 4.2.3.2 Засгийн газар | 9 | 295 | 57 | 286 | 3118% | -238 | -81% |
| 4.2.3.4 Бусад салбар | -14 | 1 | -145 | 15 | 106% | -146 | -18776% |
| 4.2.3.4.1 Богино хугацаат | -21 | -9 | 36 | 12 | 59% | 44 | 513% |
| 4.2.3.4.2 Урт хугацаат | 7 | 9 | -181 | 2 | 35% | -190 | -2026% |
| 4.2.4 Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | 0% |
| 4.2.5 Худалдааны зээл ба урьдчилгаа | -153 | -21 | -12 | 132 | 86% | 9 | 42% |
| 4.2.5.1 Богино хугацаат | -153 | 11 | -12 | 164 | 107% | -23 | -216% |
| 4.2.5.2 Урт хугацаат | 0 | -32 | 0 | -32 | 0% | 32 | 0% |
| 4.2.6 Бусад авлага | -12 | 0 | 0 | 12 | 100% | 0 | 0% |
| 4.2.7 Зээлжих тусгай эрх | -204 | -171 | -113 | 33 | 0% | 58 | 0% |
| **IV. Алдаа болон орхигдуулга** | **-271** | **-38** | **-164** | **233** | **86%** | **-126** | **-334%** |
| **V. НӨӨЦ ХӨРӨНГӨ** | **-271** | **-38** | **-164** | **233** | **86%** | **-126** | **-334%** |
| 1. ГВУН | -271 | -38 | -164 | 233 | 86% | -126 | -334% |
| 2. ОУВС-гийн зээл | 0 | 0 | 0 | 0 | 0% | 0 | - |
| 3. Тусгай санхүүжилт | -271 | -38 | -164 | 233 | 0% | -126 | - |

*Эх сурвалж:* Монголбанк

## ХАВСРАЛТ 2. ГАДААД ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ПОЗИЦИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН (сая ам.доллар)

| Үзүүлэлт | 12/31/2012 | 12/31/2013 | 3/31/2014 | 12/31/2014 | 12/31/2015 | 12/31/2016 | 3/31/2017 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц** | **(19,238)** | **(24,642)** | **(25,727)** | **(27,230)** | **(28,632)** | **(29,353)** | **(30,178)** |
| **Актив** | **6,753** | **4,340** | **4,413** | **4,045** | **3,907** | **4,309** | **3,913** |
| **Шууд хөрөнгө оруулалт** | **883** | **351** | **356** | **427** | **440** | **455** | **458** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | **817** | **282** | **286** | **355** | **366** | **380** | **382** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 817 | 282 | 286 | 355 | 366 | 380 | 382 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| *хэрэв толгой компани эдийн засгийн харьяат бол* | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| *хэрэв толгой компани эдийн засгийн харьяат бус бол* | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн хэрэгсэл** | **66** | **69** | **71** | **72** | **73** | **75** | **75** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 66 | 69 | 71 | 71 | 72 | 75 | 75 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө оруулалт) | 0 | 0 | 0 | 1 | 1 | 1 | 1 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Багцын хөрөнгө оруулалт** | **485** | **370** | **291** | **217** | **223** | **280** | **251** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | 479 | 365 | 286 | 208 | 213 | 259 | 230 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 0 | 3 | 2 | 2 | 3 | 3 | 7 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 479 | 362 | 283 | 206 | 210 | 256 | 223 |
| Бусад санхүүгийн байгууллага | 77 | 92 | 97 | 129 | 163 | 165 | 165 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 402 | 270 | 186 | 76 | 47 | 91 | 1 |
| Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бүртгэлтэй | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бүртгэлгүй | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| үүнээс: Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн бичиг** | 6 | 6 | 6 | 9 | 10 | 21 | 21 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 0 | 0 | 0 | 0 | 6 | 17 | 16 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 6 | 17 | 16 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 6 | 6 | 6 | 9 | 4 | 4 | 5 |
| Богино хугацаат | 6 | 6 | 6 | 6 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | (0) | 0 | 3 | 4 | 4 | 4 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 6 | 6 | 6 | 6 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 3 | 4 | 4 | 4 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | (0) | (0) | 0 | (0) | (0) | (0) | (0) |
| **Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион** | **0** | **49** | **164** | **121** | **114** | **100** | **55** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 0 | 49 | 164 | 121 | 114 | 100 | 55 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад санхүүгийн байгууллагууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Опцион | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Форвард хэлбэрийн хэлцлүүд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Ажилчдын хувьцааны опцион | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Бусад хөрөнгө оруулалт** | **1,259** | **1,404** | **1,658** | **1,630** | **1,807** | **2,178** | **2,040** |
| **Бусад хөрөнгө** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Бэлэн мөнгө ба харилцах** | **896** | **1,100** | **1,301** | **1,225** | **1,443** | **1,746** | **1,598** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 530 | 489 | 570 | 311 | 441 | 762 | 654 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 366 | 611 | 731 | 913 | 1,002 | 984 | 944 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Зээл** | **15** | **6** | **5** | **49** | **50** | **62** | **62** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 15 | 2 | 2 | 47 | 49 | 61 | 61 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 0 | 3 | 3 | 2 | 1 | 1 | 1 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 3 | 3 | 2 | 1 | 1 | 1 |
| **Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Худалдааны зээл ба урьдчилгаа** | **348** | **298** | **352** | **357** | **314** | **370** | **380** |
| **Бусад дансны авлага/өглөг** | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Нөөц хөрөнгө** | **4,126** | **2,166** | **1,943** | **1,650** | **1,323** | **1,296** | **1,109** |
| Мөнгөжсөн алт | 195,323 | 152,010 | 103,386 | 109,814 | 77 | 64 | 35 |
| Алтан гулдмай | 195,323 | 152,010 | 103,386 | 109,814 | 77 | 64 | 35 |
| Мөнгөжсөн биет бус алтны данс | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Үүнээс: своп хэлцлийн хүрээнд бэлэн валютаар төлөгдөх Мөнгөжсөн алт | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Зээлжих тусгай эрх | 67,988 | 66,779 | 66,577 | 62,195 | 60 | 57 | 58 |
| ОУВС-д байршуулсан хөрөнгө | 195 | 174 | 161 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад нөөц актив | 3,862,114 | 1,946,561 | 1,773,186 | 1,477,963 | 1,187 | 1,175 | 1,016 |
| Бэлэн валют ба харилцах | 2,402,714 | 1,068,329 | 1,231,578 | 716,211 | 511 | 543 | 743 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч байгууллага дахь | 2,340,902 | 1,026,278 | 1,182,544 | 659,778 | 446 | 474 | 687 |
| Бусад байгууллагад дахь | 61,811 | 42,051 | 49,034 | 56,433 | 65 | 68 | 56 |
| Үнэт цаас | 1,459,400 | 878,232 | 541,608 | 761,752 | 676 | 632 | 273 |
| Өрийн бичиг | 1,459,400 | 878,232 | 541,608 | 761,752 | 676 | 632 | 273 |
| Богино хугацаат | 1,459,400 | 874,435 | 450,631 | 761,752 | 676 | 632 | 273 |
| Урт хугацаат | 0 | 3,797 | 90,977 | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгийн хувьцаа, хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Үүнээс: репо хэлцлийн хүрээнд бэлэн валютаар төлөгдөх Үнэт цаас | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад актив | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

*Эх сурвалж:* Монголбанк

## Үргэлжлэл.

| Үзүүлэлт | 12/31/2012 | 12/31/2013 | 3/31/2014 | 12/31/2014 | 12/31/2015 | 12/31/2016 | 3/31/2017 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Гадаад хөрөнгө оруулалтын цэвэр позиц** | **(19,238)** | **(24,642)** | **(25,727)** | **(27,230)** | **(28,632)** | **(29,353)** | **(30,178)** |
| **Өр төлбөр** | **25,991** | **28,981** | **30,140** | **31,275** | **32,539** | **33,662** | **34,091** |
| **Шууд хөрөнгө оруулалт** | **17,668** | **19,579** | **19,952** | **20,247** | **20,696** | **16,277** | **16,472** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | **8,641** | **8,989** | **9,004** | **9,206** | **9,575** | **8,851** | **8,947** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 8,641 | 8,989 | 9,004 | 9,206 | 9,575 | 8,851 | 8,947 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн хэрэгсэл** | **9,028** | **10,590** | **10,948** | **11,041** | **11,121** | **7,426** | **7,525** |
| Шууд хөрөнгө оруулалттай компанид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулагч | 9,028 | 10,590 | 10,948 | 11,041 | 11,121 | 7,426 | 7,525 |
| Шууд хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулсан шууд хөрөнгө оруулалттай компани (урвуу хөрөнгө | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хамааралтай компани хоорондын | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Багцын хөрөнгө оруулалт** | **2,895** | **2,494** | **2,856** | **2,877** | **3,067** | **3,631** | **3,877** |
| **Хувьцаа ба хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрх** | 140 | 114 | 110 | 94 | 80 | 71 | 67 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 | 11 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 129 | 103 | 99 | 83 | 69 | 60 | 56 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхээс бусад хөрөнгийн үнэт цаас | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бүртгэлтэй | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бүртгэлгүй | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хөрөнгө оруулалтын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| үүнээс:  Мөнгөний захын сангийн хувьцаа/ нэгж эрх | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Өрийн бичиг** | 2,755 | 2,380 | 2,746 | 2,783 | 2,987 | 3,560 | 3,810 |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 547 | 400 | 505 | 522 | 652 | 611 | 591 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 547 | 400 | 505 | 522 | 652 | 611 | 591 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 1,587 | 1,415 | 1,395 | 1,403 | 1,473 | 2,064 | 2,918 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 1,587 | 1,415 | 1,395 | 1,403 | 1,473 | 2,064 | 2,918 |
| Бусад салбарууд | 621 | 565 | 846 | 858 | 862 | 886 | 301 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 2 | 2 | 2 |
| Урт хугацаат | 621 | 565 | 846 | 858 | 860 | 884 | 299 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) ба ажилчдын хувьцааны опцион** | **0** | **49** | **226** | **124** | **166** | **116** | **54** |
| Төв банк | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 0 | 49 | 226 | 124 | 166 | 116 | 54 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд (нөөцөөс бусад) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Бусад хөрөнгө оруулалт** | **5,427** | **6,859** | **7,106** | **8,027** | **8,610** | **13,638** | **13,688** |
| **Бусад хөрөнгө** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Бэлэн мөнгө ба харилцах** | **480** | **1,151** | **1,121** | **1,590** | **1,954** | **1,965** | **1,994** |
| Төв банк | 337 | 990 | 967 | 1,449 | 1,772 | 1,725 | 1,741 |
| Богино хугацаат | 337 | 990 | 967 | 1,449 | 1,772 | 1,725 | 1,741 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 143 | 161 | 154 | 141 | 182 | 240 | 253 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 143 | 161 | 154 | 141 | 182 | 240 | 253 |
| үүнээс: Банк хоорондын позиц | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад салбарууд | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Зээл** | **4,559** | **5,275** | **5,547** | **5,965** | **6,398** | **11,457** | **11,474** |
| Төв банк | 235 | 141 | 117 | 73 | 68 | 65 | 65 |
| ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс бусад) | 234 | 140 | 117 | 73 | 68 | 65 | 65 |
| Бусад богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгөний бодлого хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага (хамааралтай бол) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Хадгаламжийн байгууллагууд (Төв банкнаас бусад) | 486 | 815 | 895 | 1,100 | 1,294 | 1,567 | 1,538 |
| Богино хугацаат | 106 | 260 | 260 | 357 | 407 | 469 | 501 |
| Урт хугацаат | 380 | 555 | 635 | 743 | 887 | 1,098 | 1,038 |
| Засгийн газар (Төрийн удирдлагын байгууллага) | 2,012 | 2,119 | 2,140 | 2,098 | 2,287 | 2,805 | 2,927 |
| ОУВС-гаас авсан зээл (нөөцөөс бусад) | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Бусад урт хугацаат | 2,012 | 2,119 | 2,140 | 2,098 | 2,287 | 2,805 | 2,927 |
| Бусад салбарууд | 1,826 | 2,200 | 2,395 | 2,694 | 2,749 | 7,020 | 6,944 |
| Богино хугацаат | 412 | 278 | 380 | 283 | 260 | 218 | 277 |
| Урт хугацаат | 1,414 | 1,922 | 2,015 | 2,411 | 2,489 | 6,802 | 6,667 |
| Бусад санхүүгийн байгууллага | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Богино хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Урт хугацаат | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Санхүүгийн бус байгууллага, өрх, өрхөд үйлчилдэг ашгийн бус байгууллага | 1,826 | 2,200 | 2,395 | 2,694 | 2,749 | 7,020 | 6,944 |
| Богино хугацаат | 412 | 278 | 380 | 283 | 260 | 218 | 277 |
| Урт хугацаат | 1,414 | 1,922 | 2,015 | 2,411 | 2,489 | 6,802 | 6,667 |
| **Даатгал, тэтгэвэр болон стандарт баталгааны систем (F60)** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| **Худалдааны зээл ба урьдчилгаа** | **389** | **433** | **438** | **424** | **138** | **216** | **219** |
| **Бусад дансны авлага/өглөг** | **0** | **0** | **0** | **48** | **120** | **0** | **0** |

*Эх сурвалж:* Монголбанк

## ХАВСРАЛТ 3. МОНГОЛ УЛСЫН НИЙТ ГАДААД ӨР ( сая ам.доллар)

| Үзүүлэлт | 12/31/2010 | 12/31/2011 | 12/31/2012 | 12/31/2013 | 12/31/2014 | 12/31/2015 | 12/30/2016 | 3/31/2017 |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Засгийн газар | 1,882.2 | 2,043.3 | 3,599.3 | 3,534.6 | 3,500.8 | 3,759.9 | 4,868.6 | 5,844.6 |
| Төвбанк | 273.6 | 267.7 | 571.5 | 1,130.5 | 1,570.4 | 1,959.6 | 1,790.8 | 1,741.0 |
| Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад) | 512.0 | 739.8 | 1,176.0 | 1,375.8 | 1,762.2 | 2,128.5 | 2,417.4 | 2,382.5 |
| Бусад салбарууд | 1,474.3 | 1,904.7 | 2,836.1 | 3,198.7 | 3,976.6 | 3,748.9 | 8,121.5 | 7,464.4 |
| Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг | 2,985.7 | 5,952.8 | 9,027.6 | 10,590.1 | 11,040.6 | 11,120.9 | 7,426.3 | 7,525.0 |
| **Нийт гадаад өр** | **7,127.8** | **10,908.3** | **17,210.5** | **19,829.7** | **21,850.5** | **22,717.8** | **24,624.5** | **24,957.4** |

*Эх сурвалж:* Монголбанк